



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/99

Мандатговь

Хөрөнгө гаргах тухай

Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 заалт, аймгийн Засаг даргын 2014 оны А/316 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйл гардуулах, хөрөнгө зарцуулах журам"-ын 2.4 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн хурлын 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. БНСУ-ын "Экспорт-Импорт" банкны хөрөнгөөр Дулааны станцын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын хэсэг, Цэвэрлэх байгууламжийг шинээр барих асуудлаар "Азийн хөгжлийн банк"-ны нэгжийн төлөөлөгчид, Орон сууцны хороолол барих санал солилцох ажлаар БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-ны Улаанхад хотын төлөөлөгчид болон холбогдох албаны хүмүүст хүндэтгэл үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 1,341,550 /нэг сая гурван зуун дөчин нэгэн мянга таван зуун тавин/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Д.Нандинцэцэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ